



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.12.18 № 03/10664

танай _____-ны № _____-г

Хуулийн хэрэгжилт хангуулах тухай

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс, Судалгаа шинжилгээний албанаас томилогдсон ажлын хэсэг 2014 оны 09 дүгээр сарын 24-нөөс 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцлаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцахад илэрсэн зөрчил, дутагдалд дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор төлөөлөгч нарт улирлын урамшуулал олгохдоо Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан “Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд урамшуулал олгох журмыг мөрдөж ажиллах;

/Годруулбал, ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оролцсон байдал, хороо, дэд хороонд ажилласан байдал, ажлын хэсэг, түр хороонд ажилласан байдал, сонгогдсон тойрогтоо ажилласан байдал, тогтоол, шийдвэрийг олон нийтэд сурталчилсан байдал зэрэг шалгуурыг хангасан эсэхийг үнэлсэний үндсэн дээр урамшуулал олгодог байтал төлөөлөгч нарт ажлын гүйцэтгэл гараагүй байхад урамшуулал олгосон/;

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод журамд “Төрийн албанд тогтвор суурьшилтай /1-ээс дээш жил/ ажиллаж, өөрийн гэсэн орон сууцгүй байгаа ажлын албаны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, гэр бүлийг дэмжихэд зориулан жилд нэг удаа 5 000 000 /таван сая/-аас 10 000 000 /арван сая/ хүртэлх төгрөгийн буцалтгүй тусламж олгож болох”-оор тусгасан байгаа боловч ямар шалгуур үзүүлэлтээр буцалтгүй тусламжийн мөнгөний хэмжээг ялгамжтай олгох нь тодорхойгүй байх тул журмын заалтыг ойлгомжтой болгон, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны а/47 дугаар тогтоолоор “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2013 оны төлөвлөгөө”-г баталж, уг төлөвлөгөөнд БНХАУ, Болгар, ХБНГУ, Канад, Япон, БНСУ-д туршлага судлахаар тусган тухайн уг арга хэмжээнд нийт 95 450 040 /ерэн таван сая дөрвөн зуун тавин мянга дөчин/ төгрөгийг, 2014 оны а/04, а/71 дүгээр тогтоолоор баталсан “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааны 2014 оны эхний хагас жилийн болон сүүлийн хагас жилийн төлөвлөгөө”-ний дагуу Беларусь, БНХАУ, Япон, Болгар-Европын

орнууд, Герман, Швед, Болгар, Чех, Швейцарь, Канад, БНСУ-д ажлын айлчлал хийн, айлчлалын зардалд нийт 108 810 878 /нэг зуун найман сая найман зуун арван мянга найман зуун далан найм/ төгрөгийг тус тус төсөвлөн зарцуулсан байна. Цаашид гадаад томилолт айлчлалын санхүүгийн тайлан, үр дүнг тооцон олон нийтэд мэдээлэх, нээлттэй ил тод болгох;

4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас харъяа сургууль, цэцэрлэгүүдэд нэр бүхий иргэний хүүхдийг цэцэрлэгт элсүүлэх, сургуульд шилжүүлэн элсүүлэх талаар болон 3 дугаар хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргад “Фүжи Холдинг” ХХК-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах хүсэлтийг тус тус уламжилсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан “албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх” гэсэн заалттай зөрчилдөж байгааг цаашид анхааран ажиллах, давтан гаргахгүй байх;

5.Давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэмжээнд гаргаж, нээлттэй болгох;

6.Төсвийн хөрөнгийг үр дүнтэй, зориулалтын дагуу зарцуулдаг байх, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

7.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.9 дэх, Хөдөлмөрийн дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтуудыг үндэслэн ажилтан Ц.Мөнхдөлийн сургалтын төлбөрт зориулж 1 550 000 /нэг сая таван зуун тавин мянган/ төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байх боловч шийдвэрийн үндэслэл нь дээрхи хууль журмын заалттай нийцэхгүй байх тул хуулийн зохих заалтад нийцүүлэх арга хэмжээ авах.

Иймд Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг чанд мөрдөж, дээр дурдсан зөрчил дутагдлыг дахин гаргахгүйгээр ажиллах талаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан тушаалтнуудыг хамруулсан тодорхой арга хэмжээг зохион байгуулж дүнг 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ